

Шинжлэх ухааны хялбаршуулсан кино бүтээгчдийн нийгэмлэгийн продюсер, товд судлаач Г.Ням-Очир манай сонины сурвалжлагчаар ажиллах томилолт овортлоод, МУИС-ийн Нийгэм, соёл, антропологийн тэнхимийн эрхлэгч Д.Бум-Очироос ярилцлага авахаар гарлаа. Ингээд манай Уншигч-сурвалжлагчийн асуултад Кэмбрижийн их сургуулийн антропологийн доктор, профессор Д.БумОчир хэрхэн хариулсныг сонирхъя.

- Монголын шинжлэх ухааны хөгжил, эрдэмтдийн маань чадал чансаа дэлхийн шинжлэх ухаан, эрдэмтэн, судлаачдын хаахна явж байдаг юм бол. Хэрэв манай эрдэмт дийн үнэлэмж тааруу байгаа бол энэ нь юутай холбоотой гэж үздэг вэ?

- Монголын эрдэмтдийг чадварын хувьд дорой гэвэл би хүлээн зовшоорохгүй. Бид бусадтай адил бодно, сэтгэнэ. Гэхдээ асуудал бий. Хүндээ биш, тогтолцоондоо. Манайхны хэлж заншсанаар “школ” буюу шинжлэх ухааны дэг сургууль маань хуучирчээ. Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбар 1990 оноос хойш чөлөөт зах зээл, ардчилал руу шилжсэн, эсвэл шилжээд л байх шиг. Гагцхүү шинжлэх ухаан, боловсрол, соёлын салбар шилжилт эхэлсэн 23 жилийн омнох гараан дээрээ таг зогсчихсон, ийш нь оруулдаг хоронго монго ч гэж бага болохоор хөгжил цэцэглэлтийн тухай ярихад түвэгтэй.

- Миний нэг танил орос эрдэмтэн “Танай ШУА яг 1960 оны Зөвлөлтийн ШУА-тай адил байна” гэж хэлдэг юм. Тэгэхээр Монгол Улсын ШУА цаг үеэсээ бүр 60 жилээр хоцорчихсон яваа мэт гаднынханд санагддаг байх нь л дээ.

- Би нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны хүн учраас байгаагийн болон бусад салбарын тухай ярихгүй. Лав нийгэм, хүмүүнлэгийн ухаанд ШУА тодгийгүй, одоо миний ажил лаж байгаа МУИС маш бага шинэчлэл хийсэн. Манай шинжлэх ухаанд социализмын үеийн Оросын уламжлал л яваад байдаг. Гэтэл тэр нь үеэ онгороосон Зөвлөлтийн дэг л байхгүй юу. Гэтэл одоогийн Оросын шинжлэх ухаан “тасарчихсан”, аль хэдийнэ дэлхийтэй мор зэрэгцээд хөгжиж байна шүү дээ.

- За тэгвэл Монголын шинжлэх ухаан, эрдэмтэд хань татаад байдаг Орос школоосоо ч, дэлхийн твшнээс ч хоцрогджээ. Юугаараа тэр вэ?

- Эрдмийн мэдлэг, аргаараа хоцрогдчихоод байгаа юм. Шинжлэх ухаан гэдэг бол сар, жилээр биш, цаг минутаар оорчлогдон шинэчлэгдэж байдаг зүйл. Би оноодор энд нэг зүйл судлах гэж оролдоод явж байтал түүнийг маань дэлхийн хаа нэгтээ оор эрдэмтэн олж нээгээд, хэвлүүлчихэж болно. Би тэгвэл яах ёстой вэ гэвэл, тэр нээлтийг нь унших ёстой. Монголын эрдэмтдэд тулгамдаад байгаа гол бэрхшээл нь дэлхийн эрдэмтдийн судалгааны ажлыг олж уншдаггүй, цаг тухайд нь танилцдаггүй явдал. Шинжлэх ухааныг хийхийн тулд бидэнд “зэвсэг” буюу хэл хэрэгтэй байна. Харамсалтай нь, дэлхийн шинжлэх ухааныг холбож байгаа хэл бол монгол хэл биш. Социализмын үед орос хэл байсан, одоо бол миний тодорхой мэддэг нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын эрдэмтэд англи хэлээр бүтээлээ бичиж байна. Харин бид гадаад хэлгүйгээр, оороор хэлбэл, зэвсэггүйгээр шинжлэх ухаан хийх гэж оролдоод суугаад байна л даа. Тиймээс шинжлэх ухаанд бэлтгэж байгаа хүмүүсээ “зэвсэгтэй” л болгомоор байна. Дэлхийн шинжлэх ухааны алтан зарчим байна л даа. Хэрвээ чи судалгааны ажил хийх гэж байгаа бол тэр чиглэлээр дэлхий дээр гарсан бүтээлүүдтэй бүгдтэй нь танилцсан байх ёстой. Тэгээд дараа нь хийсэн юмаа аль болох хүн унших хэл дээр бичээд, эрдэм шинжилгээний тухайн салбарынхаа олон улсын хэмжээнд ондор дэсийн тэргүүлэх томоохон сэтгүүлд нийтлүүл.

- Б.Ринчен гуай “Судалгааны гурван хэлтэй, сурвалжийн гурван хэлтэй байх ёстой” гэж эрдэмтдийн “зэвсгийг” сайхан хэлсэн байдаг шүү дээ. Гэтэл манайхан сурвалжийн хэлгүйгээс бие биеийнхээ бичсэн номноос шууд хуулаад, дээр нь оороо баахан ургуулан бодоод л шинжлэх ухааны бүтээл хийчих гээд үзээд байдаг нь нууц биш. Хамгийн сүүлд Чингис хааны тухай шинээр гаргасан каталогийг академич Ш.Бира гуай шүүмжлэхийг сонслоо. Бодитой л дүгнэлт.

- Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн гээд Монголын ахмад эрдэмтдийн үед нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь маш сайн тавигдсан нь тэд орос, герман, англи хэлтэй байж. Манж, хятад, товд, перс зэрэг хэлээр эртний сурвалж бичгүүдийг судалж байсан. Харин оноодор тэр суурийг залгамжилж чадсангүй, унагачихлаа. Манай эрдэмтэд цаг үеийн зорвонд хайчлагдчихсан. Ахмадууд маань Зовлолтийн шинжлэх ухааны школтой, дунд үе нь болохоор Зовлолтийнх ч биш, орнийнх ч биш, бүр ямар ч школгүй, зүгээр л сайн дурын уран сайханчид болон хувирах аюул ирээд бүр олныг маань эзэлчихээд байна. Шилжилтийн үеийн цоорхойгоор эрдэмтдийн бүхэл бүтэн нэг үе байхгүй болсон. Одоо тэгвэл дараагийн буюу залуу үе маань “холгвйдээд” байна. Ахмад үеэ залгамжлаагүй, орчин цагийн дэлхийн шинжлэх ухаанд ойртох гээд ч хэл усгүй. “Зэвсэгтэй” залуу үеийг шинжлэх ухаанд оруулахын тулд тор засгаас хоронго оруулах зайлшгүй шаардлагатай. Боловсролын байгууллага нь ч, академи нь ч маш хатуу, ондор хариуцлагатай ажиллах

цаг болжээ. Жишээ нь, тvvхчдийн хэд нь гадаад хэлтэйг шалгах юм бол олонх нь “зэвсэггүй” байгаа. ШУА, МУИС зэрэг эрдэм шинжилгээний байгууллагууд Монголын тvvхийг судлах хvмvvсээс эртний хятад, товд, араб, перс, манж хэлтэй байхыг шаарддаг болох ёстой юм. Тэгж байж манай тvvхийн хамгийн сонирхолтой хэсэг байх учиртай эзэнт гvрнийхээ тvvхийг судална. Манай антропологи, этнологийн салбарынхан, утга зохиолынхон ч яг адилхан “зэвсэггүй” болчихоод байгаа. Монголын шинжлэх ухааны олон салбарт тулгамдсан харуусал нь энэ. Уртаашаа ганц монгол хэлтэй, тэгээд ямар сурвалж, судалгаа унших гэж байгаа юм. Оорийнхоо судалгааг дэлхийн шинжлэх ухаанд яаж хvргэх ч юм, бvv мэд. Энэ бол Монголын шинжлэх ухаан эзгvй арал дээр хаягдсан Робинзон Крузо болчихжээ л гэсэн vг. Робинзон Крузо юм хийгээд л байдаг, хэн ч тvvнийг нь олж мэддэггүй. Тэр оороо хэний ч хийсэн юмыг vздэггүй.

- Би товд судлалаар хэдэн ном гаргалаа. Тэгтэл Америкийн Дон Карон гэж эрдэмтэн “Заяын Саег” ч юм уу, дундад зууны вейн товд лам нарын одрийн тэмдэглэл мэтийг монгол хэл дээр орчуулсныг маань маш чухал сурвалж болгон ашиглахаар ирж байна. Гэтэл манай ШУА гаднын эрдэмтдийн ажлыг унших бvv хэл, оорийнхоо овийг ч танихаа больсон. Ц.Дамдинсvрэн гуайг 1980 онд таалал тогссоний дараа номын сангийнх нь номнуудыг хадгалсан байдаг. Одоо тэр их овийг таваг шолний внээр внэлдэг юм билээ. Монголын судар ном внэтэй, судлаачид нь внэ цэнэтэй байх ёстой гэдэг вээл санааг минь хуваалцахгvй юу?

-1990 оноос хойш мэдлэгтэй, боловсролтой хvн внэгvй амьтан болж хувирсан нь Монголын ганц гутамшиг шvv дээ. “Тор барихад боловсрол хамаагvй” гэж УИХ-д нэр дэвшиж байгаа хvмvvс телевизээр ярьж байхыг сонссон. Тэдний вэлээр энэ улс орныг хэн мэдлэгтэй, боловсролтой нь авч явах ёстой гэж боддог хvмvvс тэнэг юм шиг байна лээ. Тор засаг нь, ШУА нь, бага, дунд, их, дээд боловсролын байгууллага нь, сэтгvvл зvй нь оюуны ядууралтай, алслагдаж тасарсан Робинзон Крузо шиг болсон байна.

- Жишээ нь, би саяхныг болтол Утга зохиолын хvрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан байхдаа 300 мянган тогрогийн цалин авдаг байлаа. Ер нь Монголд шинжлэх ухаан хоовол иймэрхvv л орлоготой ажиллаж, амьдардаг нь жишиг юм.

- Тэгээд яаж шинжлэх ухаан хийх юм. Чиний ШУА-аас гарсан чинь зов ч байж магадгvй. Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагад ажиллаж байгаа хvмvvсийн цалин ондор байх ёстой. Гадаадад сайн боловсрол эзэмшсэн хvмvvс тэндээ влдээд байгааг ч буруутгах эрх алга. Дэлхийн том сургууль тогсчихоод 300 мянган тогрогийн толоо Монголд ирэхийн оронд, судалгаа шинжилгээний ажилд нь сайн хоронго оруулах боломжтой, эрдэм боловсролыг внэлж чаддаг орны шинжлэх ухааны байгууллагад

ажиллах нь эрдэмтэн хүнд сайхан завшаан биз дээ. Монголын эрдэмтэд хамгийн бага цалинтай, судалгааныхаа ажлыг гэр бүл, үр хүүхдийнхээ хоолноос хумсалж санхүүжүүлээд л явж байгаа. Бүр хачин зүйл юу вэ гэвэл, миний нэг танил дэлхийд чансаагаараа эхний арав дотор жагсдаг нэр хүндтэй их сургуульд доктор хамгаалаад эх орондоо иртэл орон тоогүй гээд Монголын шинжлэх ухаан, боловсролын байгууллагууд ажлын санал тавьж чадахгүй байсан тохиолдол ч бий.

- Социализмын үед манай эрдэмтдийн олонх орос хэлээр уншиж, бүтээлээ оросоор бичиж, эрдмийн цолоо ч энэ хэл дээр хамгаалж байснаас Монголын шинжлэх ухааны хэл орос болох дохсон. Сүүлийн үед Хятадын их, дээд сургуульд монголчуудыг олноор сургаж байна. Үүнд би ихэд олзуурхдаг боловч Монголын шинжлэх ухааны хэл нь хятад болох хандлага тогтох вий гэсэн болгоомж бас тордог.

- Монголоос монго гарахгүй л гэвэл манай тор засагт хамаа алга байна л даа. Ганц Хятадын Засгийн газрын тэтгэлэг биш. Үнэгүй юм гэдэг чинь аль нэг улсын бодлогоор бэлтгэж байгаа л хэрэг. Оюутолгойн ордоо ашиглана гэж бараг арван жил хэрэлдэж суухдаа тор засаг ийм хэмжээний гэрээ хийчих хүнээ сургахгүй юугаа хийж байсан юм. Үндэстэн дамнасан том корпорацитай гэрээнд гарын үсэг зурахад улс торчийн туршлагад гэхээсээ гэрээний эрх зүйг дэлхийн түвшинд, шинжлэх ухааны үндэстэй судалсан үндэсний эрдэмтэндээ найддаг байхгүй юу. Монгол Улс сэхээтнүүдээ гадаадад оорийн хоронгоор, оорийн бодлогоор сургаж авах талаар бодох цаг болсон. Тэгэхгүй бол хятад сурвалжтай, хятад шkolтой шинжлэх ухаан энүүхэнд байна шүү дээ.

- Та их сургуулийн багш хүн. Тэр дундаа дэлхийд алдартай Кэмбрижийн их сургуульд доктор хамгаалсан залуу профессор. Монголын дээд боловсролын сургалтын чанар яагаад сайжрахгүй байгаа тухайд ямар бодолтой явдгийг тань сонирхмоор байна?

- Сургалтад сүүлийн үеийн олон улсын жишгийн эрдэмтэн, судлаачдын бүтээл нэвтрэхгүй байна. Хичээлийн хотолборийн агуулгыг гадаад, дотоодын эрдэмтдийн хийсэн судалгаа, шинжилгээний ажлуудаар сэлбэж шинэчлэхгүй болохоор монгол оюутнууд яаж сайн боловсрол эзэмшиж тогсох вэ дээ. Би мор зэрэгцэн ажиллаж яваа эрдэмтэн, багш нараа шүүмжлэхээс аргагүй. Оюутнууд ярьдаг л даа. 1980-ад онд эмээд нь заасан хичээлийг одоо ач охинд нь ацаг шүдний зорьвугүй заадаг гэж. Ногоо цаг минутаар оорчлогдож шинэчлэгддэг шинжлэх ухааныг сургалтад нэвтрүүлэхгүй юм бол ямар юмных нь дээд боловсрол байх вэ дээ. Ногоотэйгүүр, сургуулийн деканыг багш нар нь сонгодог. Хэрэв нэр дэвшигч б, их, дээд сургуулийн багш нарт хичээлээ муу заасных нь толоо хариуцлага тооцох, сургалтын чагш нарын чанарын асуудалд шүүмжлэлтэй ханддаг бол нэг ч багш түүнийг сонгохгүй. Оороор хэлбэланарыг сайжруулах толовлогоотэй хүн оодоо гардаггүй

систем вйлчилж байна л гэсэн вг.

- “Ам нээвэл уушги нээ” гэдэг дээ. Шинжлэх ухаан ярьж байгаа л бол ШУА-ийн талаар зайлшгүй ярих болдог. Та бид хоёрын яриа ч энэ голдирлоор орнож байна. Би бол ШУА-ийн ажиллаж байгаа царайг “арслан нэртэй внэг”-тэй адилтгамаар санагддаг юм?

- Манай ШУА гэж хэд хэдэн академич нохдийн фракц байна. Эрдэм мэдлэгийг шударгаар внэлэхээсээ хор найруулаад л, хэнд академич цол олгох эсэхээ шийддэг. Үүнийг олон хvн мэднэ дээ, би л хэлчих шиг боллоо. Олон овгон академичаа хамруулсанд хvлцэл очье. Гэхдээ хэлэхгvй, ярихгvй байж болохгvй. Мэдлэгийн орой болсон академичид ийм байхад оюутны холбоо, зовлолоороо хор найруулж, шантааж хийх замаар монго олдог, албан тушаал авдаг оюутан дvв нарт гутаад ч яах билээ. Эрдмийн зэрэг, цол олгох зовлолvуд гэж хувийн харилцаа давамгайлсан газар байна. Доктор цол гэдэг горилсон хvн бvхэн авдаг, зовлолийн гишvуд нь тэр хvнийхээ чанартай, чанаргvй 200 хуудас ажлыг шагайж ч харалгvй хамгаалуулдаг внэ цэнэгvй зvйл болчихжээ. Жишээ нь, би Кэмбрижид доктор хамгаалахад манай ангиас одоо болтол хамгаалж чадаагvй хvн байдаг. Энэ бол шалгуур нь ондор, эрдмийн мэдлэгийг хатуу шvвж, внэ цэнэ бий болгож байгаа хэрэг.

- Яавал ШУА-ийг эрвvл саруул, дэлхийн тvвшний хогжилд ойртсон, хвчирхэг байгууллага болгох вэ?

- Лав л шинжлэх ухааныг улсторж вvлж болохгvй. Л.Гантомор байтугай мундаг сайд ирээд ч юм уу, их сургуулийн захирлуудыг халж сэлгэснээр шинжлэх ухаан хогждоггvй л дээ. Баабар гуай цохорсондоо нэг ve вхэж дуусахаар нийгэм сайхан болно гэж хатуу хэлсэн байх.

- Ер нь ШУА-ийн хэрэг байна уу. Орос, Монгол, Куба гуравт л ийм академи байдаг юм билээ. Манайхан амьдралд хэрэгжихгvй “сансрын” судалгаа хийгээд л, татвар тологчдийн монго урсгаад сууж байдаг биз дээ?

- Шинжлэх ухаан ондор хогжсон барууны орнууд, Америкт ШУА гэж байхгvй л дээ. Жишээ нь, олон оронд шаардлагатай судалгааг санхvвжvвлээд, хийж чадах эрдэмтэн, судлаачдыг сонгон шалгаруулдаг “тэтгэлэгт судлаач” гэдэг загварыг баримталдаг. Манай

ШУА олон ороо, олон хvн, чанартай, чанаргvй судалгаанд хоронго зарцуулдаг vр ашиггvй, vрэлгэн том байшин болчихоод байгаа нь vнэн. Тосвийн хоронгийг ШУА-ийн хэсэг бvлэг хvний мэдэлд огчихдог. Тэд оорийнхоо танил тал, шавь нартаа хуваарилахаа л боддог. Гэтэл ШУА-иас гадуур чанартай, сайн судалгаа хийж чадах мэргэшсэн хvмvвст эрдмийн ажил хийх гэхэд монго олодох ч vгvй. Их, дээд сургуулийн багш, судлаачдад тэр монго ирдэггvй юм. Тороос ШУА-ийг тэжээгээд, их, дээд сургуулийн багш нарын судалгааг хаячихсан атлаа оюутны сургалтын толборийг хамгийн доод хэмжээнд барих даалгавар огдог. Сургалтын толборийн 90 хувийг багш нарын цалин холсонд огчихоор vлдсэнээр нь их сургуулиуд юун судалгаа, шинжилгээ явуулах, ном авах бvв хэл цахилгаан, дулааныхаа холсийг аргацаана.

- Бум аа, Таныг дэлхийн хаана ч очсон хvлээн зовшоорно. Монголд хайртай сэтгэлээрээ л энд ажиллаад байгаа юм уу. Ми ний хувьд Тохоку, Индианагийн их сургуульд ажиллах боломжуудаас татгалзаж байсан. Эх орондоо хайртай учраас.

- Эх орондоо хайргvй хэн байгаа юм. Хайртай гэж хэлдэг мортлоо, гудамжинд шvлсээ хаядаг хvмvвс Монголоор дvврэн байна. Тийм болохоор би хайр сэтгэлд дуртай хvн биш. Монголын шинжлэх ухаан гэдгийг тодорхой хэдэн хvний сэтгэлд vврvвлж оноодрийг хvрсэн. Шинжлэх ухааныг сэтгэлд даатгаж хэр хол явах юм. Ялангуяа онго, монгоний материалист сэтгэлгээтэй болж яваа манай оноогийн нийгэмд шинжлэх ухааныг, эх орныг хайрладаг сэтгэл оноодор биш гэхэд маргааш дуусчихна. Тэгэхээр яах вэ. Тор vврэх ёстой, хариуцлагатай хандах болсон. Улсын тосвийн vлдэгдлээр шинжлэх ухааныг хооллохоо боль. Миний овгон багш нар одоо болтол хээрийн шинжилгээнд хувийнхаа зардлаар гардаг. Би ч гэсэн цалингаасаа илvвчлээд л явж байгаа.

- Та бид хоёр Монголынхоо шинжлэх ухааныг шvмжиллээ гэж шvмжлvвлэх нь гарцаагvй бол лоо шvв.

- Сайн болгох гэж хичээж байгаа учраас муугаа ярилцлаа, бас гарц хайж байна шvв дээ. ШУА-ийн удирдлага дотор ч энэ талаар санаж сэрдэг хvмvвс бий гэдэгт итгэж байна. Энэ бол энгийн шvмжлэл. Хоёр дугаарт, Монголд онолын шvмж гэж байхгvй болсон. Оноодор нэг эрдэм шинжилгээний бvтээл, яруу найргийн ном, роман хэвлэгдэхэд араас нь хэн ч шvмж бичихгvй дээ. Шvмж бол сайн муу, давуу болон сул талыг нь хэлэх шинжлэх ухааны онолд суурилсан бvтээлч сэтгэлгээ юм. Гэтэл одоо бvтээлийн шvмжийг оюуны харилцаа гэж мэддэггvй эрдэмтэд олширчихоод, хувийн харил цаатай хольж хутган дайсагнах болж.

- Боо морголийг судалж байгаагийн чинь хувьд асууя. Дэлхийн шинжлэх ухаанд сүнсийг хвлээн зовшоордог юм болов уу?

- Түвэгтэй асуудал л даа. Шинжлэх ухаан сүнсийг хвлээн зовшоороогүй. За, бас сүнс гэж байдаггүй юм аа ч гээгүй. Сүнс байхгүй гэхивэл энэ олон шашин хийгээд хүмүүсийн шүтэх, эс шүтэх эрхийг үгвйсгэсэнтэй адил болох учраас шинжлэх ухаан ямар нэг хариулт огохгүй, ероосоо аль ч салбар нь сүнсийг судалдаггүй.

- Харин манай товд судлалд сүнсний талаар арвин баялаг туршлага бий. Шинжлэх ухаан сүнсийг судлахгүй байгаагаараа бурханы шашны дэргэд арай л балчирдаад байгаа хэрэг биш үү. Монголын шинжлэх ухаан сүнсийг хвлээн зовшоорчихвол ядаж л шинжлэх ухааны бус энэ олон академи цэгцэрнэ шүү дээ.

- Сүнсийг хэн, хэрхэн нотолж, ямар аргаар хвлээн зовшоорүүлэх юм. Сүнс байгааг билгийн мэлмийгээрээ харлаа гэвэл үүнийг чинь шинжлэх ухаан ойлгохгүй. Монголын шинжлэх ухаан сүнсийг байна гээд зовшоорчихвол дэлхий доог тохуу хийж, нүүр хийх газаргүй болгоно л доо. Шинжлэх ухааны бус академиуд олноор бий болж байгаа нь Монголд эрдмийн мэдлэг үнэгүйдсэнийх, монголчууд боловсролгүй болсны шууд толь нь. Ийм хачин газруудыг Хууль зүйн яам яагаад хвлээн зовш оордгийг ойлгодоггүй юм. Сайн дурын академиудаас цол авсан хүмүүс оороосоо ичих хэрэгтэй. Академич гэдэг чинь цал буурал болтлоо шинжлэх ухаанд зүтгэж байж хүртдэг хэргэм болохоос баяраар омсдог гоёл биш. Одоо зурагтаар янз бүрийн юм ярьдаг хүн бүр ч олон болох толовтэй. Хүмүүс хэн нь шинжлэх ухаан ярьж байгааг ялгахаа больж эхэлсэн. Энэ бол Монголын бас нэг эмгэнэл.

*Тэмдэглэсэн Б.ЭНХЦЭЦЭГ*